



АТГ, ТАТВАРЫН АЛБАНЫ ХАМТАРСАН ШАЛГАЛТААР МЭДҮҮЛЭГ ГАРГАГЧДААС 569.3 САЯ ТӨГРӨГИЙН ЗӨРЧИЛ ИЛЭРЛЭЭ


Авлигатай тэмцэх газраас нийтийн албан тушаалтнуудын орлого, хөрөнгөө хууль ёсны дагуу олсон эсэх, хөрөнгийн эх үүсвэрийг нягтлан үзэхээс гадна өөрийн болон гэр бүлийн гишүүний өмчлөлд бүртгэлтэй эд хөрөнгийн орлогын эх үүсвэрийг нягтлах замаар нуугдмал эд хөрөнгө, хууль бус орлогыг илрүүлэхэд анхааран ажиллаж байна.

Уг үйл ажиллагааны хүрээнд зарим мэдүүлэг гаргагчдын мэдүүлсэн өөрийн болон гэр бүлийн гишүүдийн орлого нь үнэн бодит эсэх, хувь эзэмшдэг хуулийн этгээд, аж ахуйн нэгжүүд нь үйл ажиллагаа явуулж орлого олж, ногдол ашгийг авсан эсэх, татварын байгууллагад хуулийн этгээдийн үйл ажиллагааны талаарх тайлан, мэдээг үнэн зөв мэдүүлсэн эсэх, ХОМ-т мэдүүлсэн орлогууд нь татварын байгууллагад гаргаж өгсөн тайлан, мэдээтэй нийцэж байгаа, татвараас зайлсхийсэн үндэслэл байгаа эсэхийг нягтлан шалгуулахаар АТГ-аас санаачлан хандсанаар татварын албатай хамтран нэр бүхий иргэн, хуулийн этгээдийн орлогын байдалд холбогдох хяналт шалгалтыг явуулж байна.

Энэ төрлийн хяналт шалгалт нь иргэдийн татварын тайлан гаргалтын түвшинг нэмэгдүүлэх, орлого олсон бол тайлангаа хуулийн хугацаанд үнэн зөв тодорхойлон төлөх үүргийн хэрэгжилтийг хангуулах, цаашид хууль бус, нуугдмал орлогыг илрүүлэх, татвараас зайлсхийсэн зөрчилд хариуцлага тооцуулах, авлига, ашиг сонирхлын зөрчлийг илрүүлэхэд үр дүнтэй юм.

АТГ-ын хүсэлтээр нэр бүхий мэдүүлэг гаргагч, тэдгээрийн үүсгэн байгуулсан, хувь эзэмшиж үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд нийслэлийн Сүхбаатар, Чингэлтэй, Хан-Уул, Баянзүрх дүүргийн татварын хэлтсээс компанийн санхүү, татварын тайлан тэнцэл, нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, банкин дахь харилцах дансны хуулга, гэрээ бүртгэл тооцоо зэрэг анхан шатны санхүүгийн баримтад тулгуурласан иж бүрэн хяналт шалгалтыг явууллаа.

Шалгалтаар нэр бүхий тодорхой хуулиудыг зөрчсөн санхүүгийн зөрчлүүд



илэрсэн төдийгүй нийт 569.345.754 төгрөгийн зөрчил илэрснээс Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Татварын ерөнхий хуульд заасныг үндэслэн нийт 3 иргэн, 3 аж ахуйн нэгж, байгууллагад 42.362.496 төгрөгийн шийтгэлийн хуудсаар төлбөр ногдуулсан байна.

Авлигатай тэмцэх газраас албан тушаалтны хууль бус орлого, хөрөнгийн байдлыг илрүүлэхэд Татварын ерөнхий газар болон бусад бүртгэл, хяналтын байгууллагатай хамтран хяналт шалгалтын үйл ажиллагааг явуулах, хууль бусаар орлого олсон, үндэслэлгүйгээр хөрөнгөжиж буй зөрчлийг илрүүлэхэд анхаарч, хууль бусаар олсон орлого, хөрөнгийг хураах зэргээр хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллах болно.

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН НЭР БАРЬСАН ҮЙЛДЛИЙГ ТАСЛАН ЗОГСООВ

Авлигатай тэмцэх газрын нэр барьж тендерт дэмжлэг хүссэн, шалгагдаж байгаа асуудал дээр өмгөөлөгчөөр туслалцаа үзүүлнэ, хамаарал бүхий этгээдээ ажилд оруулах хүсэлт тавьсан зэрэг тохиолдлыг тус газрын Аюулгүй байдал, хяналт шалгалт, нууцын албанаас дотоод хяналтаараа илрүүлэн, тэдгээр хууль бус үйлдлийг таслан зогсоож харьяаллын дагуу холбогдох байгууллагад шилжүүлэн шалгуулж байна.

Тухайлбал, иргэн Б нь 2019 оны 06 дугаар сард “Гаалийн ерөнхий газарт АТГ-аас ажлаар явж байна, хувийн тендерийн асуудал дээр дэмжлэг үзүүлээд өгөөч” гэж гаалийн байгууллагын удирдах албан тушаалтантай уулзсан. 2019 оны 05 дугаар сард иргэн Э нь АТГ-т шалгагдаж байгаа хэргийг шийдвэрлэхэд өмгөөлөгч олж туслалцаа үзүүлж өгнө гэж бусдад амласан байна.

Түүнчлэн төрийн албан хаагчид нэгнийгээ АТГ-аас дуудаж байгаа мэтээр утсаар ярьж ирүүлсэн асуудал гарав. 2019 оны 10 дугаар сард Авто тээврийн үндэсний төвийн мэргэжилтэн Ж нь хамт ажилладаг Д руу утсаар ярин АТГ-аас дуудаж байна гэж хэлэн байгууллагын нэр барьжээ. Иргэн Ж-ийн дээрх үйлдэл нь Монгол Улсын Зөрчлийн тухай хуулийн 15 дугаар бүлгийн 15.21.4 дэх хэсэгт заасан зөрчсөн тул энэ талаар мэдэгдэж анхааруулсан болно.

Иргэд, олон нийтийн зүгээс авлига, ашиг сонирхлын зөрчил, авлигын гэмт хэргийн талаарх мэдээллийг шуурхай мэдээлэхээс гадна АТГ-ын болон албан хаагчийн нэр барьж хууль бус хүсэлт, шаардлага тавьсан энэ мэт үйлдлийн талаарх мэдээллийг 110 тусгай дугаарт өгч хамтран ажиллахыг хүсэж байна.



АТГ: ИРГЭН ГАРГАСАН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫНХОО ШИЙДВЭРЛЭЛТИЙГ ӨӨРӨӨ ХЯНАХ БОЛОМЖИЙГ БҮРДҮҮЛНЭ

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль тогтоомжийн хүрээнд Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсээс 2019 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр Засгийн газрын Хэрэг эрхлэх газартай хамтран төрийн байгууллагын өргөдөл, гомдол хариуцсан ажилтнуудыг оролцуулсан “Иргэдийн өргөдөл, гомдол: Шийдвэрлэлт, хяналт, тайлагналт” сэдэвт форумыг анх удаа зохион байгууллаа.

Энэхүү форумын зорилго нь иргэний гомдлыг шуурхай шийдвэрлэх, хяналт тавих боломжийг хангах, төрийн албан дахь хүнд суртлыг багасгах, авлигын эрсдлээс урьдчилан сэргийлэх, иргэдийн итгэлийг нэмэгдүүлэх, ялангуяа иргэдээс хүлээн авч буй өргөдөл, гомдлын агуулга, хянан шалгах явц, шийдвэрлэлтэд хийх дүн шинжилгээний чанар, арга зүйг сайжруулахад чиглэж, төрийн байгууллагын өргөдөл, гомдол хариуцсан ажилтнуудыг чадавхжуулах явдал юм.

Форумыг нээж Урьдчилан сэргийлэх,

тасралтгүй хийх ажил хангалтгүй байгаагаас хамааран иргэд тухайн нэг асуудлаар хаана, хэнд хандахаа мэдэхгүй байх тохиолдол гардаг нь иргэдийн бухимдлыг төрүүлдэг, мөн иргэдээс төрийн эрх бүхий дээд шатны байгууллагад хандсан асуудлыг доод шатны байгууллагад шилжүүлэх явдал хэвшмэл болсон нь иргэдийн төрд итгэх итгэлийг бууруулах хүчин зүйл болж байна. Өнөөдрийн форум энэ мэт асуудлуудыг хөндөж байгаагаараа онцлог юм” гэв.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Б.Ганбат “Төрийн албан хаагчид иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг хууль тогтоомжийн хүрээнд сайтар судлан шийдвэрлэх, өргөдөл гомдлыг ийш тийш нь шилжүүлж иргэдийг чирэгдүүлэхгүй байхад анхаарлаа хандуулан, шийдвэрлэх боломжгүй асуудалд хууль тогтоомжийн үндэслэлтэй хариу өгч, иргэдийн сэтгэл ханамжийн баталгааг хангаж ажиллах шаардлагатай. Төрийн албан хаагчдын дунд зохион байгуулж буй энэхүү форум цаг үеэ олон чухал асуудал



соён гэгээрүүлэх хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар Д.Дуламсүрэн “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль батлагдаад удаж байна. 25 жилийн хугацаанд уг хуульд хэд хэдэн удаагийн нэмэлт, өөрчлөлт орсон. Энэ хугацаанд цаг үе, нийгмээ дагаж төр, иргэний харилцаа ч мөн адил хувьсан өөрчлөгдөж байгаа тул хуулийн зохицуулалт өнөөдрийн хэрэгцээ шаардлагыг хангаж байна уу гэдгийг анхаарч үзэх шаардлагатай. Тухайлбал, энэ хуульд төрийн байгууллагууд хууль тогтоомжоор тогтоосон өөрийн эрхлэх асуудлын хүрээг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийгэд мэдээлж, сурталчлах ажлыг

болж байна” гэж онцлон тэмдэглэлээ.

Төрийн байгууллагууд Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийг хэрхэн хэрэгжүүлж байгаад хөндлөнгийн үнэлгээ хийлгэж нөхцөл байдлыг тодруулах, эрх бүхий байгууллага, албан тушаалтанд Зөвлөмж хүргүүлэхээр тогтлоо. Төрийн бүх шатны байгууллагын өргөдөл, гомдол хүлээн авах ажилтны мэдээллийн санг бүрдүүлж, төрийн байгууллагад хандсан иргэнийг тухайн байгууллагын хариуцсан ажилтантай шууд холбож иргэний гомдлыг шуурхай шийдвэрлэх, хяналт тавих нөхцөл боломжийг бүрдүүлэхийг АТГ зорьж байна.

ТӨРИЙН ТАВАН БАЙГУУЛЛАГЫН ЦАХИМ МЭДЭЭЛЛИЙГ НЭГ ХАЙЛТЫН СИСТЕМД ОРУУЛЛАА

Авлигатай тэмцэх газар, Нээлттэй нийгэм форум зэрэг байгууллагуудын дэмжлэгтэйгээр “Гэр, иргэдийн оролцоотой амьдрах орчны зураглалын төв” ТББ санаачлан төрийн таван байгууллагын нээлттэй, цахим мэдээллийг нэг хайлтын системд орууллаа.

www.opendatalab.mn хайлтын систем нь анхдагч эх сурвалжийн мэдээллийг засваргүй, ашиглахад хялбар, хүртээмжтэй байдлаар нэгтгэсэнээр онцлог юм. Энэхүү хайлтын системд хөрөнгө, орлогын мэдүүлэг, худалдан авах ажиллагаа, улсын бүртгэл, уул уурхайн лиценз, сонгууль гэсэн категори бүхий 197085 байгууллага, 489494 хувь хүн, 17026 тендер, 73189 албан тушаалтны хөрөнгө орлогын мэдүүлэг, 3356 уул уурхайн лиценз, 16 визуал дата, бүх сонгуулийн мэдээллийг багтаажээ.

“Нээлттэй өгөгдөл: Хайлтын системийг ашиглах нь” сургалтыг Авлигатай тэмцэх газар, Нээлттэй нийгэм форум хамтран 11 дүгээр сарын 4-8-ны өдрүүдэд хуульч, сэтгүүлч, иргэний нийгмийн төлөөлөгч, оюутан залууст зориулан зохион байгуулав.

Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар Д.Дуламсүрэн хэлэхдээ “Мэдээлэл, мэдлэгтэй иргэд хариуцлагыг шаардаж, эрхээ эдлэх чадвартай байдаг. Хариуцлагатай, ил тод, сайн засаглалыг бэхжүүлэхэд үнэн, бодит мэдээллийн сурвалж шаардлагатай. Энэхүү нээлттэй өгөгдлийн сан иргэд, залуусын идэвхтэй оролцоог нэмэгдүүлэхэд хувь нэмэр болно” гэж онцлон тэмдэглэв. Хайлтын системийг ашиглаж, эх сурвалжаар дурдахдаа төрийн байгууллагын анхдагч эх сурвалжтай тулгаж, нягтлах нь зүйтэй. Учир нь хайлтын системд мэдээллийг оруулах нь цаг хугацааны хязгаарлалттай тул мэдээллийн өөрчлөлт нь системд ороогүй байх, овог нэрийн давхцал гарах магадлалтай. Тиймээс Авлигатай тэмцэх газар, Худалдан авах ажиллагааны газар, Ашигт малтмалын газар, Улсын бүртгэлийн газар, Сонгуулийн ерөнхий хороо гэсэн таван төрийн байгууллагын анхдагч эх сурвалжуудаар заавал зочлохыг санаачлагчид зөвлөлөө.

ШИНЭЭР ҮҮСГЭСЭН ХЭРГҮҮДИЙГ 1-2 САРЫН ХУГАЦААНД ШУУРХАЙ ШАЛГАЖ, ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГАД ШИЛЖҮҮЛЭВ

Авлигатай тэмцэх газраас сар тутмын ээлжит хэвлэлийн хурлаа 2019 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр хийв. Хэвлэлийн хуралд тус газрын Олон нийттэй харилцах ахлах ажилтан, ахлах комиссар Т.Баярхүү оролцож, цаг үеийн асуудлаар сэтгүүлдэд мэдээлэл өгөв.

Оны эхний 10 сард 326 албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийг хянан шалгав

2019 оны эхний 10 сарын байдлаар 326 албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг /ХАСХОМ/-ийг шалгаж, хуульд заасан зөрчилтэй мэдүүлсэн 35 албан тушаалтанд хариуцлага тооцуулсан байна. Хариуцлага тооцуулсан байдлыг авч үзвэл: 4 албан тушаалтанд сануулах, 21 албан тушаалтанд албан тушаалын цалин бууруулах, 2 албан тушаалтанд албан тушаал бууруулах, 8 албан тушаалтанд ажлаас халах хариуцлага тус тус оногдуулсан байна.

Албан тушаалтны авлига, ашиг сонирхлын зөрчлийг шалгуулахаар хандсан 631 өргөдөл, гомдол, мэдээллийг хянан шийдвэрлэсэн байна. Өргөдөл, гомдлын мөрөөр албан тушаалтны буруутай үйл ажиллагааг илрүүлж, зөрчил гаргасан 37 албан тушаалтанд хариуцлага тооцуулж, эрх бүхий байгууллага, албан тушаалтны хууль бус шийдвэрийг хүчингүй болгох, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, зөрчил арилгуулах, тухайн зөрчил үүсэх, эсхүл олон нийтийн зүгээс ашиг сонирхлын зөрчилтэй гэж үзэх нөхцөл байдлыг үүсгэж байгаа нөхцөлийн талаар анхааруулсан зөвлөмж бүхий 46 албан бичиг хүргүүлсэн. Хариуцлага тооцуулсан байдлыг авч үзвэл: 7 албан тушаалтанд сануулах, 23 албан тушаалтанд албан тушаалын цалин бууруулах, 4 албан тушаалтанд албан тушаал бууруулах, 3 албан тушаалтанд ажлаас халах хариуцлага тус тус оногдуулсан байна.

Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн 7727 этгээдийн ХАСУМ-ийг хүлээн авснаас 7570 этгээдийн урьдчилсан мэдүүлгийг хянан шийдвэрлэж холбогдох байгууллагад хариуг хүргүүлэв. Үүнээс ашиг сонирхлын зөрчил үүсэж болохуйц нөхцөл байдлыг тогтоож 634 мэдүүлэгт анхааруулга бичиж, хууль, журамд заасан шаардлага хангаагүй үндэслэлээр 303 мэдүүлгийг буцаан хүргүүлж, 26 нэр дэвшигчийг тухайн албан үүргийг хэрэгжүүлэхэд илт ашиг

сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал бий болсон талаарх дүгнэлтийг холбогдох байгууллагад хүргүүлсэн байна.

1316 үйлдэлтэй, 433 холбогдогчтой, 1115 хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулаад байна

2019 оны эхний 10 сарын байдлаар гэмт хэргийн шинжтэй 698 гомдол, мэдээлэл шалгасан. Хүлээн авч шалгасан 698 гомдол, мэдээллээс 370 гомдол, мэдээлэл буюу 53.0 хувьд хэрэг бүртгэлтийн хэрэг нээх, 285 гомдол, мэдээлэл буюу 40.8 хувьд хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах, 27 гомдол, мэдээлэл буюу 3.9 хувийг харьяаллын дагуу шилжүүлэх саналтай тус тус прокурорт шилжүүлж, шийдвэрлэлт 97.9 хувьтай байна.

Эхний 10 сарын байдлаар 1316 үйлдэлтэй, 433 холбогдогчтой, 1115 хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан байна. Нийт шалгасан хэргийн 125 буюу 11.2 хувийг шүүхэд шилжүүлэх саналтай, 460 буюу 41.5 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг хаах саналтай, 64 буюу 5.7 хувийг харьяаллын дагуу шилжүүлэх саналтай прокурорт шилжүүлж, 21 хэргийг нэгтгэн шалгаж, 3 хэргийг түдгэлзүүлж, одоо 442 эрүүгийн хэргийн үлдэгдэлтэй байгаагаас хэрэг бүртгэлтийн 389 хэрэг, мөрдөн байцаалтын 53 хэрэг байна. Шүүхээр 42 хэрэг эцэслэн шийдвэрлэгдсэн байна.

Мөрдөн шалгах ажиллагааны явцад 7.6 тэрбум төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлжээ

Энэ хугацаанд гэмт хэргийн улмаас 12,078,285,989,959 төгрөгийн хохирол учирснаас мөрдөн шалгах ажиллагааны явцад 7,627,356,525 төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж үл хөдлөх, хөдлөх, байр, орон сууц, автомашин, тоног төхөөрөмж зэрэг 136,869,098,344 төгрөгөөр үнэлэгдэх эд хөрөнгө болон бэлэн мөнгийг битүүмжлэн хамгаалсан байна.

Учирсан хохирлыг өмнөх оны мөн үетэй харьцуулбал, гэмт хэргийн улмаас учирсан хохирол 36.4 дахин, битүүмжлэн хамгаалсан хөрөнгө 1.4 дахин, хохирол нөхөн төлүүлэлт 14.8 дахин нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Үүнийг авлигын гэмт хэрэг ихээр нэмэгдээд байгаа гэж тайлбарлах нь буруу. Харин хэд хэдэн хэргийг шалгах явцад тогтоосон хохирлын хэмжээ их байгаа. Тухайлбал, нийт хохирлын дийлэнх хувь нь Эрдэнэт үйлдвэрийн 49 хувьтай холбоотой хэрэг, Жаст компанийн захирал Ш.Батхүү нарт

холбогдох хэргийн хүрээнд тогтоогдсон хохирол гэдгийг зөвөөр ойлгох хэрэгтэй.

Зөвхөн 10 дугаар сард 32 эрүүгийн хэргийг шүүхэд шилжүүлэх саналтай прокурорт шилжүүлэв

АТГ-ын удирдлагууд шинээр томилогдсоны дараа хэрэг шалгах ажлыг эрчимжүүлэх албан даалгавар гаргаж авлигын гэмт хэргүүдийг хурдан хугацаанд шалгаж шийдвэрлэхэд анхаарал хандуулан ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд олны анхаарал татсан, удаан хугацаанд шалгагдсан хэргүүдийн мөрдөн шалгах ажиллагааг дуусгаж прокурор, шүүх рүү шилжүүлээд байна. Тухайлбал, Оюу толгойн гэрээтэй холбоотой С.Баяр, Ч.Сайханбилэг, С.Баярцогт нарт холбогдох хэрэг, Улаанбаатар хотын дарга асан Э.Бат-Үүлд холбогдох хэрэг, Ерөнхий сайд асан М.Энхсайхан нарт холбогдох хэрэг, ХХААХҮ-ийн сайд асан Б.Батзориг болон ЖДҮХС-гийн эрх бүхий албан тушаалтнуудад холбогдох хэрэг, Салхитын мөнгөний ордтой холбоотой шүүгч нарт холбогдох хэрэг, Хөгжлийн банкны ТУЗ-ийн дарга асан Б.Шинэбаатар, гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан Н.Мөнхбат нарт холбогдох хэрэг, “Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн дарга Л.Пүрэвбаатар нарт холбогдох хэрэг гэх мэт хэргүүдийг дурдах боломжтой. Зөвхөн 10 дугаар сард л гэхэд 32 эрүүгийн хэргийг шүүхэд шилжүүлэх саналтай прокурорт шилжүүлсэн байна.

Түүнчлэн сүүлийн үед шинээр шалгасан хэргүүдийг шуурхай шалгаж, эрх бүхий байгууллагад шилжүүлэв. Зам, тээврийн хөгжлийн сайдаар ажиллаж байсан Д.Ганбат, ЗТХЯ-ны газрын даргаар ажиллаж байсан Д.Доржханд, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дарга Ч.Алтанхуяг, "ДЦС-2" ТӨХК-ийн гүйцэтгэх захирал С.Бямбаахүү нарт холбогдох хэргүүдийг шалгах ажиллагааг 1-2 сарын хугацаанд дуусгаж прокурор, шүүх рүү шилжүүлээ. Төрийн өндөр албан тушаалтнууд холбогдсон хэргийг шалгах явцад хэргийн цар хүрээ, үйлдэл нэмэгдэж байгаа ч мөрдөн шалгах ажиллагааг тасралтгүй, шуурхай явуулж байна.



М.ДАВААТОГТОХ: ЯВЦЫН ДУНД ИТГЭЛ АЛДАРСАН БАЙДАЛД

-Ерөнхий сайд асан С.Баяр, Ч.Сайханбилэг, Сангийн сайд байсан С.Баярцогт нарыг шалгаж дууссан-



Авлигатай тэмцэх газар (АТГ)-ын Мөрдөн шалгах хэлтсийн орлогч бөгөөд нэгдүгээр албаны дарга, ахлах комиссар М.Даваатогтохтой олны анхаарал татсан зарим хэргийн шалгалтын явцын талаар ярилцлаа.

-Танай Мөрдөн шалгах хэлтэс хуулиар хүлээсэн чиг үүргээ ямархуу хүн, хүчтэйгээр хэрэгжүүлж байна вэ?

-АТГ-ын Мөрдөн шалгах хэлтэс нь Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт хуульчилсан 11 төрлийн гэмт хэрэг, мөрдөн шалгах ажиллагааны явцад өөрсдийн илрүүлсэн мөнгө угаах гэмт хэрэг болон Улсын ерөнхий прокурорын 2017 оны А/67 дугаар тушаалаар баталсан зааврын дагуу цагдаагийн албан хаагчийн үйлдсэн гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж байна.

Манай хэлтсийн 36 мөрдөгч дээрх мөрдөн шалгах чиг үүргийг улсын хэмжээнд хэрэгжүүлж байгаа тул маш өндөр ачаалалтай ажилладаг. Авлигын гэмт хэргийг эрх мэдэлтэй, хөрөнгө мөнгөтэй, тусгай мэдлэг бүхий хүмүүс үйлддэг тул илрүүлж, мөрдөн шалгаж нотлоход ур чадвар, цаг хугацаа, зардал асар их шаарддагаараа бусад хэргээс онцлогтой. Авлигын гэмт хэргийн

нэг холбогдогчийн ард 2-3 өмгөөлөгч, санхүүгийн тусгай мэдлэг бүхий зөвлөх гээд бүхэл бүтэн баг ажилладаг. Ганц мөрдөгч ийм хэмжээний мэргэшсэн багтай тулж, хэргийг нотлон, прокурор, шүүхээр шийдвэрлүүлэхээр ажиллаж байна. Авлига, албан тушаалын нэг хэрэгт цугларч байгаа нотлох баримт дунджаар 20-300 хавтас болдог нь бусад төрлийн 20-30 эрүүгийн хэрэг мөрдөн шалгасантай адил хэмжээний хөдөлмөр, цаг хугацаа шаарддаг.

-Төрийн өндөр албан тушаал хашиж байгаа, өмнө нь хашиж байсан хүмүүсийг авлига, албан тушаалын хэрэгт холбогдуулан танайхаас баривчилсан. Ер нь авлигатай тэмцэх ажил улам ширүүсэж, иргэдийн ярьдагчлан “акул”-уудыг шалгаж эхлээд байна.

-Олон нийт өндөр хүлээлттэй байгаа “шударга ёсны хүсэмжлэл”-д бодит хариулт өгөх үүргийг АТГ-ын шинэ удирдлага бүх ажилтанд өгсөн. Тэр дундаа авлигын гэмт хэргийг бүрэн илрүүлж, шуурхай шийдвэрлэх, энэ төрлийн хэргийн улмаас хулгайлагдсан, нуун дарагдуулсан хөрөнгийг хамгаалах, битүүмжлэх, буцаан төлүүлэхэд онцгой ач холбогдол өгч байгаа.

Хуулийн байгууллагаас сүр дуулиантай баривчилгаа хийдэг ч явцын дунд хэрэг нь замхардаг гэх иргэдийн итгэл алдарсан байдалд цэг тавих цаг нь болсон гэж үзэж байгаа. АТГ-аас нэг сар гаруйн өмнө дайчлан баривчилсан Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дарга Ч.Алтанхуяг, Зам, тээврийн яамны газрын даргаар ажиллаж байсан Д.Доржханд нарын хэргийг шалгаж дуусгаад шүүхэд шилжүүлэх саналтайгаар НПП-г хүргүүлжээ. Мөрдөн шалгах хэлтсийн зүгээс хуульч, шуурхай ажиллагааг эрхэмлэн хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэх болно.

-“Эрдэнэт үйлдвэр”-ийн 49 хувийг хууль бусаар худалдан авсан зэрэг олны анхаарал татсан томоохон хэргийн мөрдөн байцаалтын явцын талаар тантай уулзсаных асуухгүй өнгөрч болохгүй байх. Иргэд ч дээрх хэргээс гадна Ерөнхий сайдаар ажиллаж байсан хүмүүс, Улсын ерөнхий прокурор асан гээд олны анхаарал татсан зарим хэргийг хэрхэн шийдвэрлэснийг анхааралтай ажиглаж байгаа шүү дээ.

-Тус хэлтсээс мөрдөн шалгах ажиллагаа явуулсан хэд хэдэн хэргийг прокурорын

хяналтад шилжүүлээд байна. Тухайлбал, Монгол Улсын Ерөнхий сайд асан С.Баяр, Ч.Сайханбилэг, Сангийн сайд байсан С.Баярцогт нарын холбогдсон, Монгол Улсын сайд асан М.Энхсайханд холбогдох үйлдэл, нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч байсан Э.Баг-Үүл нарын, Салхитын мөнгөний ордтой холбоотой шийдвэр гаргах явцдаа авлигын хэрэгт холбогдсон нэр бүхий зургаан шүүгчийн, Архивын ерөнхий газрын дэд даргаар ажиллаж байсан албан тушаалтан зэрэг 32 хүн холбогдсон Ховд аймагт хууль бусаар ашигт малтмал олборлосон хэрэг, ЭМДЕГ-ын дарга Ч.Алтанхуяг нарын, “Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн дарга асан Л.Пүрэвбаатарын, “ДЦС-2” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал С.Бямбаахүү нарын, Хөгжлийн банкны гүйцэтгэх захирал байсан Н.Мөнхбат нарт холбогдох зэрэг авлигын 39 хэргийг энэ оны есдүгээр сарын 25-наас арваннэгдүгээр сарын 8-ныг хүртэлх сар гаруйн хугацаанд шүүхэд шилжүүлэх саналтайгаар НПП-ын хяналтад шилжүүлжээ.

Түүнчлэн Ерөнхий сайд асан Ж.Эрдэнэбатад холбогдох, “Дарханы гурил тэжээл” ХК-ийн чанарын шаардлага хангахгүй, ашиглах боломжгүй элеваторыг 16 тэрбум төгрөгөөр төрд худалдсан үйлдэл, ЭМЯ-ны албан тушаалтнууд хахууль авч тусгай зөвшөөрөл хууль бусаар олгосон, Хөгжлийн банкны нэр бүхий албан тушаалтнуудад холбогдох гээд олны анхаарал татсан хэргүүдийг ойрын хугацаанд шүүхэд шилжүүлэх саналтайгаар прокурорын байгууллагад хүргүүлнэ.

-Авлига, албан тушаалын хэрэгт сэжиглэн танайхаас баривчилсан хүмүүс удалгүй баглан даалтад гарах, суллагдах нь түгээмэл. Мөрдөн байцаалт, хяналт шалгалтыг хэрхэн явуулж байна вэ. Хууль, эрх зүйн ямар үндэслэлээр хэргийн холбогдогч нар сул чөлөөтэй болоод байдаг юм бол?

-Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг шинэчлэн баталж, 2017 оны долдугаар сарын 1-нээс хүчин төгөлдөр мөрдөж байгаа. Энэ хуулиар сэжигтнийг баривчлах болон яллагдагчийг цагдан хорих үндэслэл өөрчлөгдсөн. Өмнө мөрдөж байсан Эрүүгийн байцаан шийтгэх хуульд хээл хахууль авах гэмт хэргийг хүндрүүлэх бүрэлдэхүүнтэйгээр үйлдсэнд сэрдэгдсэн

ХЭРЭГ ЗАМХАРДАГ ГЭХ ИРГЭДИЙН ЦЭГ ТАВИХ ЦАГ БОЛСОН

сэжигтэн, яллагдагчийг хэргийн бодит байдлыг тогтооход саад учруулахаас сэрэмжлэх зорилгоор цагдан хорьж шалгах боломжтой байсан юм. Өөрөөр хэлбэл, авлигын гэмт хэргийн нийгмийн аюулаас хамаарч хэргийн бодит байдлыг тогтоохын тулд сэжигтэн, яллагдагчийг цагдан хорьж мөрдөн байцаалт явуулдаг байв.

Одоо мөрдөж буй Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар дээрх зохицуулалтыг хүчингүй болгосноос авлигын гэмт хэргийн нийгмийн аюулаас хамаарч яллагдагчийг цагдан хорьж, мөрдөн шалгах ажиллагаа явуулах боломжгүй болсон. Энэ нь хорьж саатуулсан этгээдийг суллах гол шалтгаан болж байна.

-Хэрэг мөрдөх явцад томоохон албан тушаалтнууд нөлөөлдөг гэх яриа, шүүмжлэл бий. Өмнө нь ийм агуулгатай мэдэгдэл та бүхэн хийж, хэрэгт нөлөөлөх гэж оролдвол хуулийн хариуцлага хүлээлгэнэ гэдгийг анхааруулж байсан. Олон улсын судалгааны байгууллагын дүн мэдээлэлд ч хэрэгт “гомчууд” нөлөөлөх гэж оролддог гэсэн утгатай дүгнэлт байсан.

-Улс төрийн өндөр албан тушаалтнууд мөрдөн шалгах ажиллагаанд нөлөөлөхийг хуулиар хориглосон. Эрүүгийн хуулийн 21.6 дугаар зүйлд мөрдөгч, прокурор, шүүгчид хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааг эрхлэн явуулахтай нь холбогдуулан хууль бусаар нөлөөлөх үйлдлийг гэмт хэрэгт тооцож, хуульчилсан.

Мөрдөншалгах ажиллагаанд нөлөөлөхийг санаархдаг улстөрчид байдгийг үгүйсгэхгүй. Гэхдээ миний мэдэж буйгаар, тухайлсан хэрэгт улс төрийн албан тушаалтнууд хууль бусаар нөлөөлж, уг нөлөөллийнх нь дагуу гэмгүйг гэмтэн болгосон, гэмтэй нэгнийг хаацайлсан тохиолдол байхгүй. Мөрдөн шалгах ажиллагаа нь зөвхөн хуульд заасан үндэслэл, журмын дагуу явах ёстой, хууль бусаар мөрдөн шалгах нь өөрөө гэмт хэрэг. Иймд хэн нэг албан тушаалтны “нөлөөгөө” ашиглаж өгсөн хууль бус үүргийн дагуу мөрдөгч шалгаж хэрэгтэн болох замыг сонгохгүй. Тэгээд ч АТГ-ын мөрдөн шалгах ажиллагаа нь холбогдох хуульд заасны дагуу прокурорын хяналтад байдаг.

Авлига, албан тушаалын гэмт хэрэгт шалгуулсан, шүүхээр шийтгүүлсэн олонх албан тушаалтан “хэлмэгдэгсдийн дүр”-д хувирдаг. Хулгай хийсэн, төрд болон бусдад учруулсан гэм буруугаа хүлээн зөвшөөрч

гэмшиж байгаа албан тушаалтан гэж бараг алга. Шалгуулж байгаа албан тушаалтнууд АТГ-ын үйл ажиллагааг бүх талаар харлуулах гэсэн, өөрсдийгөө энхийн цагаан тагтаа мэт ойлголтыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан нийгэмд бий болгож, бидний үйл ажиллагаанд нөлөөлөхийг оролддог. Энэ явуургүй арга гэдэг нь цаг хугацааны явцад харагдаж байгаа.

Улс төрийн намууд болон нэр дэвшигчид сонгуулийн үед гэмт хэргийг, тэр дундаа авлигыг бууруулах чиглэлээр тодорхой ажлууд хийхээр мөрийн хөтөлбөртөө тусгаж, сонгогчдод амладаг. Сонгуулийн үр дүнд улс төрийн албан тушаалтан болсон хүмүүс мөрийн хөтөлбөрөө хэрэгжүүлэх зорилгоор АТГ-аас үр дүн шаардах тохиолдол байдаг.

-Авлигын гэмт хэргийг мөрдөн шалгахад өнөөдөр тулгамдаж буй хамгийн том бэрхшээл юу байгаа бол?

-Авлигын гэмт хэргийг мөрдөн шалгахад учирч байгаа бэрхшээлүүдийн нэг нь хохирогчийн асуудал. Хувь хүн өөрийнхөө хэтэвчнээс мөнгөө хулгайд алдвал уг зөрчигдсөн эрхээ сэргээлгэхээр тууштай явдаг. Харин авлигын гэмт хэргийн улмаас улс оронд олон тэрбум, их наядаар хэмжигдэх хохирол учирч байхад үүний араас тууштай явах хохирогч тэр бүр байдаггүй. Үүний шалтгаан нь нэгдүгээрт, төрийн эрх ашгийг тууштай хамгаалах эзэнгүйтэй холбоотой. Хоёрдугаарт, монголчууд авлигын хор хөнөөлийн талаар хангалттай ойлголтгүйгээс шалтгаалдаг болов уу. Миний хэтэвчнээс мөнгө алдагдаагүй юм чинь гэсэн хандлагаар авилгад хандаж болохгүй. Авлига бол хөгжил цэцэглэлтийн, эрүүл мэндийн, бүтээн байгуулалтын эсрэг гэмт хэрэг.

Утаатай гэмцэх зориулалтаар төсөвлөсөн олон тэрбум төгрөгийг хулгайлсны төлөөсийг иргэд эрүүл мэндээрээ төлж байна. Автозамын ажлын төсвийг хулгайлж чанаргүй, нарийхан зам ашиглалтад оруулсны төлөөсийг амиараа төлдөг, бондын мөнгийг эрх мэдэлтэй албан тушаалтнууд завшсаны төлөөсийг та бид, цаашлаад үр хүүхдүүд маань ч үргэлжүүлэн төлөхөөр байгаа. Авлигын хор уршгийг нийгмийн гишүүн бүр асар их үнээр төлж буйгаа ойлгож, энэ төрлийн гэмт хэрэгтэй тууштай гэмцэх, иргэдийг соён гэгээрүүлэхэд бүх хүнийг, тэр дундаа урлаг, спорт, шинжлэх ухааны алдартнуудыг дэмжлэг үзүүлнэ үү гэж уриалах.

Авлигын гэмт хэргийг мөрдөн шалгах

эрх зүйн орчин учир дутагдалтай байгаа нь энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхэд томоохон саад учруулдаг. УИХ-ын дарга Г.Занданшатар авлигын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг уртасгах, оноож байгаа ял шийтгэлийг чангаруулах асуудлыг судалж, хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулсан нь цаг үеэ олсон, авлигатай хийх тэмцэлд ихээхэн дэмжлэг үзүүлэх ажил болж байна. Уг ажлын хэсэг авлигын гэмт хэргийг мөрдөн шалгахад учирч байгаа саад бэрхшээлийг арилгасан хууль батлуулна гэсэн итгэлтэй байгаа.

“Эрдэнэт үйлдвэр”, “Монголросцветмет”-ийн 49 хувьд ногдох хөрөнгө, ашигт малтмалын үнэлгээ 9.3 их наяд төгрөг

-Нийтийн албанд эрх бүхий албан тушаал хашиж байсан хүмүүсийн хахууль авсан үйлдэл, эд мөрийн баримтыг танайхан хэвлэлийнхэнд мэдээлсэн. Гэтэл зарим хүн үүнийг хүний эрх зөрчлөө хэмээж байгаа. Тухайн хүний эрх зөрчигдсөн үү, эсвэл тэр авлигачийн үйлдлээс болж ард иргэдийн эдлэх эрх алдагдсан уу. Та үүнд ямар бодолтой явдаг вэ?

-Монголчууд “нэр хугарахаар яс хугар” хэмээн ярьж, нэр төрөө машинд эрхэмлэдэг ард түмэн. Авлига бол улс орны хөгжил цэцэглэлтийн, эрүүл мэндийн, бүтээн байгуулалтын эсрэг гэмт хэрэг гэдгийг өмнө хэлсэн. Авлигач албан тушаалтнууд өөрсдийн болон гэр бүл, удмынхаа нэр төрийг ч уландаа гишгэж та бидний, үр хүүхдүүдийн маань ирээдүйгээс хулгайлж байна. Авлигаас урьдчилан сэргийлэх, олон нийтийг соён гэгээрүүлэх нь АТГ-ын үндсэн чиг үүргийн нэг. Энэ чиг үүргийнхээ хүрээнд шүүхээр шийдвэрлэсэн зарим хэргийн мөрдөн шалгах ажиллагааны баримтаас олон нийтэд үзүүлсэн. Цаашид ч энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүргийнхээ хүрээнд авлигачдын гэмт хэрэг үйлдэж байгаа баримт нотолгоог олон нийтэд үзүүлэх боломжтой. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор олон нийтэд мэдээлэл түгээх нь олон улсад тогтсон, хууль ёсны жишиг.

Хууль ёсны дагуу, ёс зүйтэй амьдрах нь нэр төр, эрх чөлөөгөө хамгаалах дархлаа юм. Албан тушаалтнууд нэр төр, эрх чөлөөгөө өөрсдөө хүндэтгэж авлигын гэмт хэрэг үйлдээгүй бол ийм бичлэг цацагдахгүй гэдэг нь ойлгомжтой.

Үргэлжлэл нь VI нүүрт

М.ДАВААТОГТОХ: ЯВЦЫН ДУНД ХЭРЭГ ЗАМХАРДАГ ГЭХ ИРГЭДИЙН ИТГЭЛ АЛДАРСАН БАЙДАЛД ЦЭГ ТАВИХ ЦАГ БОЛСОН

Үргэлжлэл. Түрүүч нь IV, V нүүрт

-Авлигын гэмт хэргийн улмаас улсад 11.9 их наяд төгрөгийн хохирол учирсан гээд байгаа. Ийм их хэмжээний хохирол учирсан гэхээр олон хүн итгэдэггүй. Энэ дүн ямар үндэслэлээр яаж гарч ирэв. Ямар хэргүүдийн холбогдогч нар ийм их хохирол учруулаад байна вэ?

-Тус хэлтэс 2019 оны эхний 10 сарын байдлаар 1000 гаруй хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж байна. Эдгээрийн дотор төр, нийгэмд ноцгой хохирол учруулсан олон хэрэг бий. Тухайлбал, Монгол Улсын Засгийн газар “Эрдэнэт үйлдвэр”, “Монголросцветмет” компанийн 49 хувийн энгийн хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах давуу эрхээсээ холбогдох хууль тогтоомж зөрчин татгалзсаны улмаас төрийн эрх ашигт их хэмжээний хохирол учруулсан үйлдэлтэй эрүүгийн хэргийг АТГ, ЦЕГ-ын хамтарсан ажлын хэсгийнхэн мөрдөн шалгаад дуусаж байна. Засгийн газраас томилсон хохирогчдын нэхэмжлэл болон мэргэшсэн үнэлгээчдийн дүгнэлтээр “Эрдэнэт үйлдвэр”, “Монголросцветмет” компанийн 49 хувьд ногдох нийт хөрөнгө болон ашигт малтмалын үнэлгээ нь 9.3 их наяд төгрөг гэж тогтоогдсон нь тус хэлтэсээ мөрдөн шалгасан хэргийн хохирлын дүн огцом өсөх үндэслэл болсон.

Үндсэн хуулийн цэцийн 2018 оны хоёрдугаар сарын 28-ны 03 дугаартай дүгнэлтээр УИХ-ын “Эрдэнэт үйлдвэр”, “Монголросцветмет” компанийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2017 оны хоёрдугаар сарын 10-ны тогтоол нь Үндсэн хууль зөрчөөгүй гэж дүгнээд, 49 хувийн хувьцааг төрийн мэдэлд авсан тохиолдолд ОХУ-ын “Ростех” корпорацад уг 49 хувийн энгийн хувьцааг авахад зарцуулсан төлбөрийг төлж барагдуулах үүрэгтэй гэж шийдвэрлэснийг холбогдох байгууллагаас өмнө нь олон нийтэд мэдээлж байсан.

-Авлига, албан тушаалын гэмт хэрэг шийдвэрлэх дагнасан шүүх байгуулах талаар та юу гэж үздэг вэ? Хонконгийн их сургуулийн профессор Тони Квоккийн ярилцлагад дагнасан шүүх үр дүнтэй гэж дурдсан байсан.

-Авлигын гэмт хэргийг дагнасан прокурор, шүүхээр шийдвэрлүүлэх нь авлигатай



амжилттай тэмцэх чухал шийдлийн нэг. Индонез, Филиппин, Тайланд, Пакистан, Малайз, Украин зэрэг хүн ам олонтой орнууд авлигын эсрэг дагнасан шүүх байгуулан энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх оролдлого хийж байна. Хүн ам цөөнтэй, сайн яривал хоорондоо төрөл садан, хамаатан, хамааралтай болчих гээд байдаг манай улсын хувьд авлигын гэмт хэргийг хянан шийдвэрлэх дагнасан прокурор, шүүх байгуулах нь энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхэд онцгой ач холбогдолтой. Аливаа зүйлээр дагнасан хүн илүү амжилт гаргах, эрдэлээс хол байх боломжтой байдаг. Энгийн жишээгээр тайлбарлая. Мэдрэлийн эмч хэзээ ч зүрхний мэс засал хийдэггүй. Тодорхой чиглэлээр мэргэшсэн эмч болохын тулд олон жил суралцаж байж эмчлэх эрхээ авч, уг мэргэшлээрээ л дагнан ажилладаг. Хүний эрүүл мэнд чухал, гэхдээ нийгмийн өвчин болсон авлигыг эмчлэх нь үүнээс дутахгүй чухал ач холбогдолтой. Эрүүгийн хуульд заасан 209 төрлийн гэмт хэргээр нэг шүүгч бүрэн мэргэших боломж муутай. Монголын шат шатны эрүүгийн хэргийн шүүхийн шүүгч нар бүх төрлийн хэргийг хянан шийдвэрлэдэг. Тэр дундаа орон нутгийн нөлөө бүхий албан тушаалтнуудын үйлдсэн авлигын хэргийг орон нутгийн шүүх хянан шийдвэрлэж буй нь мэдрэлийн эмчээр зүрхний мэс засал хийлгэж байгаатай адил, мэргэжлийн алдаа гарах магадлал өндөр. Олон жил нэг аймаг, суманд ажилласан танил хүмүүс урьдын тогтоосон харилцаагаараа

шүүгчид нөлөөлөхөд илүү хялбар, нөгөө талаас шүүгч өөрийн танилуудад, магадгүй найз нартаа ял шийтгэл ногдуулна гэдэг хүн ёсны хувьд хэцүү байх нь мэдээж. Гэвч өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж буй хуулиар орон нутгийн шүүгч, орон нутгийн албан тушаалтнуудад холбогдох хэргийг хянан шийдвэрлэх үүрэгтэй.

Авлигын хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх нь өндөр ёс зүй, мэргэжлийн нарийн ур чадвар шаардсан ажил. Тийм ч учраас Монголын төр авлигатай тэмцэх тусгайлан чиг үүрэгтэй, хараат бус, бие даасан байгууллагыг 2007 онд байгуулсан. Авлигын гэмт хэргийг мөрдөн байцаах, хянах ажлын эцсийн үр дүнг хэмжих, шударга ёс тогтоох алтан дэнс болсон шүүхийн тогтолцоо урьдын хэвээрээ байгаад дүгнэлт хийж, авлигын гэмт хэргийг хянан шийдвэрлэх дагнасан шүүх байгуулах ёстой гэж боддог. Ядаж Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд авлигын хэргийг давж заалдах шатны шүүх анхан шатны журмаар шийдвэрлэдэг зохицуулалт оруулж өгөх зайлшгүй шаардлагатай гэж үзэж байна.

-Эрүүгийн хуульд заасан авлигын гэмт хэрэгт ногдуулж байгаа ял хөнгөн, шүүх хэрэгтнүүдийн толгойг илж байна гэж иргэд шүүмжилдэг. Үүнд та ямар байр суурьтай байдаг бол?

-Эрүүгийн хуулиар авлигын гэмт хэрэгт ногдуулж байгаа ял шийтгэл тухайн гэмт хэргийн нийгмийн аюултай харьцуулахад хөнгөн байгаа. Автотээврийн үндэсний төвийн албан тушаалтан 57.5 сая төгрөгийн хахууль авсан гэмт хэрэгт шүүх 6 сая төгрөгөөр торгох ял оноосон нь үүний бодит жишээ.

Малайз улс хахууль авах гэмт хэрэг үйлдвэл авсан хахуулийн мөнгийг нь 5 дахин нугалж торгодог. Авлигын гэмт хэргийг хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй үйлдвэл 20 жил хүртэл хорих ял оноодог. Австрали улс авлигын гэмт хэрэгт гэм буруутайд тооцсон этгээдэд 10 хүртэл жилийн хорих ял ногдуулж, 1.1 сая хүртэл австрали доллар буюу 2 тэрбум орчим төгрөгөөр торгох ял шийтгэдэг. Гадаадын улс орнууд авлигын гэмт хэрэгт өндөр дүнтэй торгуулийн ял оноон, эдийн засгийн аргаар энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэж байгаа сайн туршлагыг нутагшуулбал үр дүнтэй гэж боддог.

Ярилцсан Г.ЦОЛМОН

ХОЁР ӨГҮҮЛБЭРЭЭР

Авлигатай тэмцэх газраас “Дээд боловсролын салбар, орчин дахь ёс зүйн тандалт судалгаа”-ны ажлыг хийж байна. Багш, эмч, эрх зүйч зэрэг иргэдэд нийтлэг үйлчилгээ үзүүлдэг ёс зүйн өндөр хэм хэмжээг өдөр тутам чанд сахин мөрдөх шаардлагатай мэргэжилтэн бэлтгэдэг их сургуулийн ёс зүйн орчин, ёс зүйн хичээлийн хөтөлбөрт үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид сургалтын хөтөлбөрийн чанар, үр өгөөжийг дээшлүүлэх зорилгоор 843 оюутан, 110 багш, албан хаагчаас анкетын судалгаа авч, дээрх 3 сургуулийн сургалтын хөтөлбөрт шинжилгээ хийж тайланг боловсрууллаа.

Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсээс “Улаанбаатар төмөр зам”-ын алба, хэлтэс, төв, салбар нэгжийн удирдах, дунд шатны ажилтнуудын сургалтад оролцон, “Авлигын хор хөнөөл”, “Авлигаас урьдчилан сэргийлэх арга зам” сэдвээр хичээл зааж, авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлав.

Улаанбаатар төмөр замын ажилтнууд хууль дээдлэх, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, гэмт хэрэг гарах шалтгаан, нөхцөлийг арилгах, авлига албан тушаалын гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор жил бүр зохион байгуулдаг “Вагонтай сургалт”-ыг 2019 оны 11 дүгээр сарын 11-23-ны өдрүүдэд төмөр замын урд, хойд чиглэлд явууллаа.

Авлигатай тэмцэх газрын санаачилгаар Барилга, хот байгуулалтын яамтай хамтран Авлигын эсрэг олон улсын өдрийг угтан салбарын яам, агентлагийн асуудал хариуцсан нэгжийн удирдлагууд, барилгын салбарын ТББ-ын төлөөллүүд, барилгын компанийн удирдлагуудыг оролцуулан “Мэргэжлийн холбоодод шилжүүлсэн барилгын тусгай зөвшөөрлүүд: Асуудал, шийдэл” сэдэвт хэлэлцүүлгийг Авлигатай тэмцэх газрын Олон нийтийн төвд зохион байгууллаа.

Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагад шилжүүлснээр гарч буй хандлага, ололт дэвшил, учирч буй бэрхшээл, түүнийг шийдвэрлэх гарц боломжийг төр, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын төлөөллүүдийг байлцуулан дүгнэн хэлэлцсэнээрээ өнөөдрийн арга хэмжээ онцлог байлаа.

ҮНДЭСЛЭЛГҮЙГЭЭР ХӨРӨНГӨЖСӨН ҮНДЭСЛЭЛЭЭР 21 АЛБАН ТУШААЛТНЫГ НАРИЙВЧЛАН ШАЛГАЖ БАЙНА

Авлигатай тэмцэх газраас албан тушаалтны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, мэдээллийн мөрөөр, төлөвлөгөөт хяналт шалгалтын хүрээнд нарийвчлан хянан шалгадаг бөгөөд 2019 он гарсаар 305 албан тушаалтны мэдүүлгийг нарийвчлан шалгаж шийдвэрлэсэн байна.

Үүнээс 20 гаруй хувийг нь иргэдээс ирүүлсэн гомдол, мэдээллийн мөрөөр, үлдсэн хувийг нь төлөвлөгөөт хяналт шалгалтын хүрээнд хянан шалгажээ. Шалгалтаар зөрчил гаргасан, орлого хөрөнгөө худал мэдүүлсэн нийт 37 албан тушаалтанд сануулах, цалин бууруулах, нийтийн албанаас халах хүртэлх сахилгын арга хэмжээ тооцуулахаар эрх бүхий байгууллагад хүргүүлснээс 8 албан тушаалтныг нийтийн албанаас чөлөөлүүлсэн байна.

Хяналт шалгалтаар өөрийн болон гэр бүлийн гишүүдийн орлого, хөрөнгийг хууль ёсны дагуу бий болгосныг үндэслэлтэй тайлбарлаж нотолж чадаагүй нэр бүхий 21 албан тушаалтныг үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн гэх үндэслэлээр тус газрын холбогдох хэлтэст шалгуулахаар шилжүүлснээс ТӨХК-ийн удирдах албан тушаалтан 2, яамны газар хэлтсийн дарга 2 болон анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгч нар зэрэг албан тушаалтнууд байна.

АЛБАН ТУШААЛТАН ХӨРӨНГӨ, ОРЛОГООС ГАДНА ХЭРЭГЛЭЭ, ЗАРЛАГАА МЭДҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ

Авлигатай тэмцэх газар “Албан тушаалтны хөрөнгө, орлогод иргэдийн хяналтыг нэмэгдүүлэх, ХОМ-ийн маягтыг боловсронгуй болгох нь” сэдэвт хэлэлцүүлгийг 2019 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр “Блю скай” төвийн хурлын танхимд зохион байгууллаа.

Уг арга хэмжээний үеэр албан тушаалтны хөрөнгө, орлогод иргэдийн хяналтыг хэрхэн нэмэгдүүлэх, дан ганц орлого, хөрөнгийг бүртгэхээс гадна зарлагын асуудлыг хэрхэн тусгах, олон улсад төрийн албан хаагчдын хөрөнгө, орлогыг хэрхэн бүртгэж, хянадаг, манай улсад ХОМ-ийг хянан шалгахад гарч байгаа хүндрэл бэрхшээл, тулгамдаж байгаа асуудал, хэрэгцээ шаардлагын талаар хэлэлцэж байна. Хэлэлцүүлэгт төрийн байгууллага, иргэний нийгэм, төрийн бус байгууллага, иргэдийн төлөөлөл оролцож, албан тушаалтны хөрөнгө, орлогод тавих иргэдийн хяналтыг нэмэгдүүлэх, мэдүүлгийн маягтыг улам боловсронгуй болгохоор саналаа гаргаж нэгтгэв.

Авлигын эсрэг хууль тогтоомжид зааснаар нийтийн албан тушаалтан нь өөрийн болон гэр бүлийн гишүүдийн орлого, хөрөнгийг үнэн зөв мэдүүлэх үүрэгтэй. Авлигатай тэмцэх газраас албан тушаалтнууд нь тухайн орлого, хөрөнгийг хууль ёсны дагуу олсон эсэх, хөрөнгийн эх үүсвэрийг нягтлан үзэхээс гадна өөрийн болон гэр бүлийн гишүүний өмчлөлд бүртгэлтэй эд хөрөнгийн орлогын эх үүсвэрийг нягтлах замаар нуугдмал эд хөрөнгө, хууль бус орлогыг илрүүлэхэд анхааран ажиллаж байгаа боловч хянан шалгах үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд зарим томоохон хүндрэл, бэрхшээл учирсаар байна.

Тухайлбал, ХОМ-ийн хяналт шалгалтын хүрээнд албан тушаалтан, түүний хамаарал бүхий этгээдүүдийн банкны данс, гүйлгээтэй холбоотой мэдээллийг гаргуулан авах боломжийг хуульчлан тогтоогоогүй нь албан тушаалтны үндэслэлгүйгээр хөрөнгөжих зөрчил, нуугдмал хөрөнгийг илрүүлэх ажиллагаанд томоохон бэрхшээл учруулж байгаа ба тухайн албан тушаалтны өөрийн гаргаж өгч буй мэдээллээр хязгаарлагдах, хяналт шалгалтын үйл ажиллагаанд шаардлагатай нотолгоог бүрэн цуглуулах, хугацаа алдах зэргээр хяналт шалгалтын үйл ажиллагаанд хүндрэл учирч байна.

Өмнө нь зөвхөн төрийн өндөр албан тушаалтнуудын ХОМ-ийг олон нийтэд мэдээлдэг байсан бол мэдүүлгийн цахим системийн үйл ажиллагааг сайжруулсантай холбоотойгоор 2018 онд нийт 35700, 2019 онд нийт 36800 орчим мэдүүлэг гаргагчийн ХОМ-ийн хураангуйг АТГ-ын цахим мэдээллийн сүлжээнд байршуулсан. Мэдүүлгийг нээлттэй, ил тод байршуулж иргэдийн хяналтад ийнхүү өгч байгаа нь авлига, ашиг сонирхлын зөрчил, авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чухал үйл ажиллагаа юм. Нөгөө талаас ХОМ гаргах нь нийтийн албан тушаалтны шударга ажиллаж байгаа гэдгээ олон нийтэд нээлттэй харуулах баталгаа нь болдог билээ.



ГОМДОЛ, МЭДЭЭЛЭЛ ХҮЛЭЭН АВАХ УТАС



ГОМДОЛ, МЭДЭЭЛЭЛ ХҮЛЭЭН АВАХ УТАС

“ХҮН БОЛОХ БАГААСАА” ЭССЭ БИЧЛЭГИЙН УРАЛДААНЫ ДҮН ГАРЛАА

Авлигатай тэмцэх газраас соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүрээнд ерөнхий боловсролын сургуулийн 9-12 дугаар ангийн сурагчдын дунд зарласан “Шударга ёс: Хүн болох багаасаа” сэдэвт эссэ бичлэгийн уралдааны дүн гарлаа.

Ахлах ангийн сурагчид шударга ёсны тухай үзэл бодлоо эссэ бичлэгээр дамжуулан илэрхийлэх, шударга бус байдлын эсрэг олон нийтэд дуу хоолойгоо хүргэх нь уг уралдааны гол зорилго байв. Уралдаанд нийт 129 эссэ ирүүлсэн байна. Эдгээрээс:

Тэргүүн байранд нийслэлийн Хан-Уул дүүргийн 52 дугаар сургуулийн 10г ангийн сурагч Э.Хүслэн (25 оноогоор),

Дэд байранд нийслэлийн Сүхбаатар дүүргийн 1 дүгээр сургуулийн 116 ангийн сурагч Б.Гоомарал (24 оноогоор),

Гуравдугаар байранд Баян-Өлгий аймгийн “Дарын” цогцолбор сургуулийн 10а ангийн сурагч Б.Жантолхын (23 оноогоор) нар шалгарлаа.

Уралдаанд идэвхтэй хамрагдсан Архангай, Баян-Өлгий, Говь-Алтай, Ховд, Баянхонгор аймгийн болон нийслэлийн Багануур дүүргийн цогцолбор сургууль, нийслэлийн 5, 2, 37, 84, 105, 21, 1, 107, 40, 81, 49, 113, 6, “Ирээдүй”, “Монгени” цогцолбор, “Путонхуй”, “Тоомарал” дунд сургуулийн сурагчиддаа баярласнаа илэрхийлэе.

“АВЛИГЫГ
ЭСЭРГҮҮЦЭХ НЬ
ЗАЛУУСЫН
ҮҮРЭГ ЮМ.

КУРТ КОБЕЙН
ДУУЧИН, NIRVANA



АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР
<https://www.iaac.mn>

ГОМДОЛ, МЭДЭЭЛЭЛ
ХҮЛЭЭН АВАХ
/ТӨЛБӨРГҮЙ/ УТАС



Эхийг бэлтгэсэн: Т.Мөнхтунгалаг
Гэрэл зургийг Б.Барбаатар, А.Санжаа

Мэдээллийн хуудасны талаарх санал, сэтгэгдлийг
70112463 дугаарын утсаар хүлээн авна.